

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХАЯГДАЛ УСНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ДОРЖДАГВЫН ЧУЛУУНХҮҮГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДАХИН АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Усны нөөцийг тогтоох, усны нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, бохирдол, хомсдлоос сэргийлэх							
"Алсын хараа 2050" хөтөлбөрийн зорилт 5.1.2, 6.3, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 6.3.1, ЗГ-ын 2024-2028 оны ҮАХ-ийн 2.4.3.6, 2.4.3.7, 3.4.1.7, 3.4.2.5, 3.4.3.4, 4.3.1.4, БОУАӨЯ-ны стратегийн зорилт 4.1.4.2, 4.3.4.4, 4.5; Усны газрын стратеги төлөвлөгөөний 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6.2.7							
Зорилт 1. Усыг дахин ашиглах бодлогын хэрэгжилтийг хангах, дахин ашиглалтын нөөц бүрдүүлэх төлөвлөлтийг хэрэгжүүлэн мэдээллийг тайлагнах.							
1.	Арга хэмжээ 1.1. Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, урамшууллын механизмыг хэрэгжүүлж мэдээг Татварын албанд хүргүүлсэн байх.	Хүргүүлсэн мэдээний тоо	4	Эхний хагас жил: Ус бохирдуулагчдын 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын хөнгөлсөн, чөлөөлсөн төлбөрийг тооцож, Татварын албанд хүргүүлсэн байна.	58 дүгнэлтээр Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8.1.2 дахь заалтаар аж ахуйн нэгж байгууллагын дахин ашигласан хаягдал усны төлбөр болох 2.5 сая төгрөгийг 100% чөлөөлж, 8.3 дахь заалтаар төсвөөс санхүүждэг боловсролын салбарын 235 байгууллагаас 28 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын 59 байгууллагаас 13.05 сая төгрөгийг хөнгөлж, хот, суурин газрын цэвэрлэх байгууламжид бохир ус нийлүүлсэн 3022 хуулийн этгээдэд 75.12 сая төгрөг ногдуулж, цэвэрлэх байгууламж хариуцсан хуулийн этгээдийн төлбөрөөс хөнгөлсөн. Мөн 41,367 айл өрхийн 139 сая төгрөгийг хаягдал усны дүгнэлтээр чөлөөлсөн байна. дүн мэдээг нэгтгэж 2024 оны 12 сарын 15 болон 2025 оны 04 дүгээр сарын 14-нд тус тус татварын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн.	01-06	100%
Зорилт 2. Хаягдал усны хэмжээ, чанарын хяналт шинжилгээ, төлбөр, хууль дүрэм журам, стандартын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.							

2.	Арга хэмжээ 2.1. Хуульд заасан чиг үүргийн дагуу хаягдал усны дүгнэлт гаргах	Шийдвэрлэсэн хүсэлтийн хувь	2024 онд 177 хүсэлтийн дагуу хаягдал усны дүгнэлт 100 хувь гаргасан.	Эхний хагас жил: Хаягдал усны дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нь 100 хувь цахимаар гаргасан байна.	I сард 18, II сард 9, III сард 5, IV сард 17, V сард 9, VI сард, Нийт 58 ирсэн хаягдал усны дүгнэлтийг 100% цахимаар гаргаж ААНБ-д хүргүүлсэн.	01-06	100%
3.	Арга хэмжээ 2.2. Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр тооцож ногдуулах	Хүргүүлсэн мэдээний тоо	4	Эхний хагас жил: Ус бохирдуулагчдын 2024 оны IV улирал, 2025 оны I улирлын төлбөр, нөхөн төлбөрийг тооцож, Татварын байгууллагад хүргүүлсэн байна.	58 дүгнэлтээр ус бохирдуулсны төлбөрт 79 сая төгрөг, нөхөн төлбөрт 118 сая төгрөг тооцож ногдуулан, 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 197 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрсөн байна. 2024 оны 12 сарын 15 болон 2025 оны 04 дүгээр сарын 14-нд тус тус татварын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн.	01-06	100%
4.	Арга хэмжээ 2.3. Ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны хэмжээ, чанарын төлөв байдалд хяналт тавин шаардлагатай тохиолдолд газар дээр нь хяналтын сорьцын шинжилгээ авч ажиллах.	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	3 удаагийн томилолтоор 8 ААНБ-ын хаягдал усанд газар дээр нь хяналтын сорьцын шинжилгээ авч, төлбөр, нөхөн төлбөр ногдуулж, зөвлөмж, шаардлага хүргүүлсэн.	Эхний хагас жил: Урьдчилсан сэргийлэх болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 3-аас доошгүй бохирдуулагч үйлдвэрүүд болон уул уурхайн технологийн хаягдал уснаас хяналтын сорьцын шинжилгээ авч ажилласан байна.	Салбарын хяналтын ерөнхий байцаагч Б.Мөнхтогтохын баталсан 2025 оны 01/08 дугаар бүхий "Урдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага оврын цэвэрлэх байгууламжааса гарч байгаа хаягдал усны стандартын шаардлагыг хангуулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" хяналт шалгалтын удирдамжийн дагуу 2025 оны 6-р сарын 5-6-нд БОУАӨЯамны Салбарын хяналтын газар, Туул голын сав газрын захиргаатай хамтран Эмээлт орчмын мах, махан бүтээгдэхүүн, өлөн дайвар боловсруулах үйлдвэрүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	01-06	100%
5.	Арга хэмжээ 2.4. Сав газрын захиргаадын хаягдал усны талаарх дүн мэдээг нэгтгэж, тайлагнах.	Хянаж нэгтгэсэн тайлангийн тоо	4	Эхний хагас жил: Сав газрын захиргаадын гаргасан дүгнэлт, төлбөр, зөвшөөрөл, гэрээний дүн мэдээг улирал бүр цахимаар хүлээн авч, хянан дүн мэдээг 2 удаа Татварын албанд хүргүүлсэн байна	2025 оны эхний таван сарын байдлаар 21 Сав газрын захиргаанаас хаягдал усны дүгнэлтийг мэдээгээр 17 сав газарт нийт 3481 хаягдал усны дүгнэлт гарган, 2.16 сая м³ бохир усанд 123.8 сая төгрөгийн төлбөр ногдуулсан байна. Үүнээс боловсролын салбарын 397 байгууллагад 41 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын 159 байгууллагад 35.26 сая төгрөгийн	01-06	100%

					хөнгөлөлт тооцож мөн 6631 айл өрхийн төлбөрөөс 13.5 сая төгрөгийг чөлөөлж, 2892 ус бохирдуулагч аж ахуйн нэгжид 56.7 сая төгрөг ногдуулсан дээрх мэдээг нэгтгэж УХШХэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Хишигдуламд 2025.05.30 өдөр нэгтгэсэн мэдээ тайланг өгч ажилласан.		
Зорилт 3. Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах, усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах.							
6.	Арга хэмжээ 3.1. Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.	Усны чанарын үнэлгээ хийсэн сумын тоо	-	Эхний хагас жил: Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн 44 сумын усны чанарт үнэлгээ хийх ажлын хуваарь гаргаж, бэлтгэл ажлыг хангасан байна.	БОУАӨСайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/275 дугаар "Төсвийн зардлын хуваарьт өөрчлөлт оруулж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар 2025 оны А/78 дугаар тушаалыг хүчингүй болгосноор Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах ажлын 200 сая төгрөг хасагдаж, ажлыг зогсоосон байна. Усны хяналтын төв лаборатори Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Сайншанд сумын малчдын унд ахуйн гүний худгуудаас 2 удаагийн давтамжтай, 8 цэгээс дээж авч хими, нянгийн шинжилгээг хийж усны газрын даргад гарсан үр дүнг танилцуулж, "БАДРАХ ЭНЕРЖИ" ХХК-д дүгнэлт зөвлөмж хүргүүлэн, цаашид давтамжийг сар бүр тогтмол авч цооног болон ойр орчмын гүний худгуудаас мониторинг хийх ажлын төлөвлөгөө гаргаж, ажлын хэсгийн ахлагч Ус ашиглалтын хэлтсийн дарга /Х.Мягмаржав/-д өгч ажилласан.	01-06	100%
Зорилт 4. Улсын усны төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлж, усны бохирдлыг бууруулах суурь мэдээллийг бүрдүүлэх, шинжилгээ хийх							
7.	Арга хэмжээ 4.1. Голын ёроолын хурдас цэвэрлэх Catfish төхөөрөмжийг ажиллуулж, Туул голын ёроолын хурдсыг цэвэрлэх.	Ажлын гүйцэтгэлийн хувь	Catfish төхөөрөмжийг худалдан авсан.	Эхний хагас жил: Тоног төхөөрөмж ажиллуулах байршлыг тогтоон, төсвийн тооцооллыг гаргаж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжид хүргүүлсэн байна.	Туул голын лаг, хагшаасыг цэвэрлэх ажлын хүрээнд Инженер геологи номт ХХК-ийн ерөнхий инженер Л.Бархасаар Төв цэвэрлэх байгууламжаас Туул голд цутгах цэгээс эхлэн урсгалын дагуу 21 км хүртэлх зайг хамран нийт 34.69 км	01-06	100%

					голдирлыг цэвэрлэх зардлын тооцооллыг гаргуулж, нэмэлт зардлын эх үүсвэрийг олохоор ажиллаж байна. Дээрх ажлыг "Вотер реоври" ХХК хийж гүйцэтгэнэ.		
8.	Арга хэмжээ 4.2. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилгоор уул уурхайн ажилчдын хотхоныг ариутгах татуургын хувьд бие даасан, байгальд ээлтэй, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг зохион байгуулах хүрээнд холбогдох шийдвэрүүдийг гаргах.	Албан мэдэгдэл хүргүүлсэн хувь	-	Эхний хагас жил: Ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламжийн судалгаа гаргасан байна.	Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй нийт 700 гаруй Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид олборлолт явуулж байгаа бөгөөд эдгээрийн 40 хувь буюу 280 нь стандартын шаардлага хангасан цэвэрлэх байгууламжтай, 50 хувь буюу 350 нь түр шийдэл (зөөврийн жорлон, септик систем гэх мэт) ашиглаж байгаа бол 10 хувь буюу 70 нь ариун цэврийн байгууламжийн хувьд бүрэн шийдэлгүй, шаардлага хангахгүй нөхцөлд үйл ажиллагаа эрхэлж байна.	01-06	100%
9.	Арга хэмжээ 4.3. Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-нд заасны дагуу урьдчилан цэвэрлэх байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэхээр шаардлага хүргүүлэх.	Шаардлагын тоо - 70	-	Эхний хагас жил: Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг хэрэгжүүлж, технологид нийцсэн цэвэрлэх байгууламжтай болгох талаар судалгаанд авагдсан 70 үйлдвэрт шаардлага хүргүүлсэн байна.	Бохирдуулагч 70 үйлдвэртэй утсаар холбогдож Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн судалгаа гаргахад Очир дагинас ХХК, Жүр үр ХХК цэвэрлэх байгууламж шинээр барьж, АПУ ХК цэвэрлэх байгууламжаа 2025.06.10-нд шав тавихаар ажиллаж байгаа, ТЭСО ХХК зураг төслөө батлуулсан. Бусад үйлдвэрүүд судалж байгаа, барих газар талбай байхгүй, хуучин цэвэрлэх байгууламжаа шинэчилж байгаа, зураг төсөл хийлгэж байна. Судалгааны мэдээллийг БОУАӨЯам, ХББОСЯам, ММССанд хүргүүлсэн. 2025 онд бохирдуулагч 70 үйлдвэрийн холбогдох дарга, менежертэй утсаар холбогдон шаардлага тавьж ажилласан.	01-06	100%
Зорилт 2. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ Усны тухай хуулийн 16 ¹ дугаар зүйлийн 16 ¹ .4.8, 24 дүгээр зүйлийн 24.2, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль							
Зорилт 6. Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн, цэвэр усны үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, хууль эрхзүйн орчныг бүрдүүлж, усны нөөцийн нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлж, усны төлбөр үнэ тарифын уялдаа холбоог сайжруулах.							
10.	Арга хэмжээ 6.1. Аж ахуйн нэгж байгууллагуудад усыг зохистой ашиглах, усны	Хянаж нэгтгэсэн тайлангийн тоо	2	Эхний хагас жилээр: Сав газрын захиргаагаас ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж	2025 оны эхний хагас жилийн байдлаар 17 сав газрын	01-06	100%

	нөөцийг хэмнэх, тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, усны алдагдлыг бууруулах, ус ашиглалтыг бодитоор тооцох, тоолууржуулах ажлыг тайлагнах хэрэгжилтэд хяналт тавих			байгууллагын тоолууржуулалтын мэдээг авч нэгтгэн гаргасан байна	захиргаанаас ирүүлсэн тоолуурын мэдээг нэгтгэн боловсруулалт хийхэд 382 айл өрх, ААНБ-ын 176 ширхэг усны тоолуурыг суурилуулахад нийт 95,977,390 төгрөг зарцуулсан байна.		
11.	Арга хэмжээ 6.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж өгөх.	2023 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж өгсөн.	Эхний хагас жилээр: Албан тушаалтны 2024 оны хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж өгөх.	Албан тушаалтны 2023 оны хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж УСХ-н дарга Д.Сайханжаргалд баталгааны хуудсыг гарган өгч албажуулан ажилласан.	01-02	100%
ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ /Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль/							
Зорилт 7. Агентлагийн хэвийн үйл ажиллагааг ханган, хууль тогтоомжийн хэрэгжилтийг түгээн дэлгэрүүлэх, олон нийттэй харилцах							
12.	Арга хэмжээ 7.1. Төрөөс усны талаар баримтлах дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах.	Арга хэмжээний тоо	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдааг сайжруулах чиглэлээр 5 удаагийн ажил зохион байгуулсан.	Эхний хагас жил: 1. Ус бохирдуулсны төлбөрийн мэдээллийг ewater.mn цахим системээр Татварын албанд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна. 2. Сав газрын захиргаадын албан хаагчдыг цахим системд ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж ажилласан байна.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, эрх зүйн зохицуулалт болон MNS 6561:2024 шинэчилсэн стандартын хэлэлцүүлгийг Усны газрын Хатантуул танхимд, 2025.03.27-нд цахимаар амжилттай зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлэгт БОУАӨЯамны мэргэжилтэн Д.Давааням, СГЗ-ны мэргэжилтэнүүд, Усны газрын УНХ, УХШХэлтсийн дарга, мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 30 хүн оролцсон.	01-06	100%
13.	Арга хэмжээ 7.2. Олон нийтийн устай холбоотой хэвцмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах.	"Цэнхэр алт" үндэсний чуулган зохион байгуулах. Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажил зохион байгуулах"	2024 онд "Цэнхэр тууз" аяныг зохион байгуулсан	Эхний хагас жил: Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчлах хүрээнд "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан сарын аян зохион байгуулах.	2025 оны 3-р сарын 21-нд Төрийн ордны Их Монгол танхимд болсон "ЦЭНХЭР АЛТ" Усны салбарын Үндэсний II чуулганы бэлтгэл ажлыг амжилттай зохион байгууллаа. Чуулганы үр дүнтэй, зохион байгуулалт сайтай болохын тулд урьдчилсан бэлтгэл ажлыг нарийн төлөвлөж, шат дараалсан арга хэмжээнүүдийг гүйцэтгэв. Бэлтгэл ажлын хүрээнд:	01-06	100%

					Чуулганы техник, дэд бүтцийн бэлтгэлийг хангаж, шаардлагатай тоног төхөөрөмж, танхимын тохижилтыг хариуцсан. Олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр чуулганы үйл ажиллагааг шууд дамжуулах ажлыг зохион байгуулж ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Үүрэг даалгавар 1.1. Агентлагийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу томилолтоор ажиллах, ажлын хэсэгт орж ажиллах.	Томилолтоор болон ажлын хэсэгт орж ажиллах.	2	Эхний хагас жил: Хөдөө орон нутагт батлагдсан удирдамжийн дагуу томилолтоор ажилласан байна. Ажлын хэсэгт орж ажилласан байна.	Газрын даргын баталасан удирдамжийн дагуу 2025 оны 5-р сарын 6-9-нд Архангай аймгийн Хотонт суманд болсон голын сав газрын мэргэжилтнүүдийн туршлага солилцох практик сургалтад оролцож, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, рашааны ашиглалт, хамгаалалтын журам, Хөв цөөрөм сэдвээр илтгэл тавилаа. Мөн 2025 оны 5-р сарын 28-30-ний өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Монголын говийн биологийн олон янз байдал форумд "Говийн усны асуудал сэдэвт хэлэлцүүлэг"-ийг зохион байгуулж оролцсон.	01-06	100%
2.	Үүрэг даалгавар 1.2. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажиллах.	Жил бүр	Эхний хагас жил: ТАХ-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах	ТАХ-ийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025.01.10-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний эхний хасаг жилийн биелэлтийг гарган удирдлагад хүргүүлэн ажилласан.	01-06	100%

3.	Үүрэг даалгавар 1.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.	Шийдвэрлэсэн хүсэлтийн хувь	100	Эхний хагас жил: Тайлант хугацаанд хуваарилагдан ирсэн хүсэлтүүдийг хүлээн авч, холбогдох байгууллагуудад хариуг цаг тухайд нь хүргэж, шуурхай шийдвэрлэн.	Тайлант хугацаанд нийт 59 албан бичиг хуваарилагдан ирсэн бөгөөд эдгээрийг хүлээн авч, хариуг нь цаг тухайд нь гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.	01-06	100%
----	--	-----------------------------	-----	---	---	-------	------


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдах.	Цахим сургалт	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй онлайн богино хугацааны 4-н сургалтад суусан.	3 кредит	2025.01.10-аас 2025.05.31-ийн хооронд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй онлайн богино хугацааны 6-н сургалтад суусан.	01-06	100%
2.	Арга хэмжээ 2. Монгол бичгийн сургалтад хамрагдах.	Танхим болон цахим сургалт	Монгол бичгийн дунд шатны цахим сургалтад хамрагдаж Үнэмлэхийг 2024.05.31-д авсан.	-	Цахим сургалтад хамрагдаж Бие даан сурч байна.	01-06	100%
3.	Арга хэмжээ 3. Удирдлагын академийн Төрийн захиргааны ахлах түшмэлийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Суралцсан кредит цаг	Удирдлагын Академийн "Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын хөтөлбөр"-т 2020. 09.17-2021.01.14 хүртэл хугацаанд хамрагдаж сертификат авсан.	9 кредит	Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлсэн 9 багц/цаг сургалтад амжилттай хамрагдаж 2025 оны 3 сарын 24-ний өдрийн А/151 тоот тушаалаар сертификат авсан. /голч 3.07 оноо /	04-04	100%
4.	Арга хэмжээ 4. Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдах.	Суралцсан кредит цаг	-	Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгүүлэх суурь мэдлэг олгох сургалтад амжилттай сурч АЗ-гэрчилгээг 2025 оны 04 сарын 14 өдөр авсан.	01-04	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЧУЛУУНХҮҮ



2025.06.05